



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/547

Улаанбаатар хот

**Хан-Уул дүүргийн Буянт-Ухаа
цогцолбор сургуулийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 11,706,283.37 /арван нэгэн сая долоон зуун зургаан мянга хоёр зуун наян гурван төгрөг гучин долоон мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн Буянт-Ухаа цогцолбор сургууль /Ө.Болормаа/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй номыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн Буянт-Ухаа цогцолбор сургууль /Ө.Болормаа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 6 өдрийн 01572 тоот тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүрэг Буянт-Ухаа цогцолбор сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Эвдрэл гэмтэл	ЭБХХХК-ын хурлын шийдвэр
1	Сурах бичиг	4-7	ш	8,002		11,706,283.37	-	-	ашиглагдахгүй	устгах
Номын фондын дүн						11,706,283.37	-	-		
Нийт дүн						11,706,283.37	-	-		
Үүнээс: Худалдах хөрөнгө										
Актлах хөрөнгө						11,706,283.37				
Татан төвлөрүүлэх хөрөнгө										
Худалдсанаас олох орлого										
НӨАУГ-т төвлөрүүлэх /30 %/										